



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/17

Мөрөн сум

**Комисс томилох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 70,71,72,73 дахь заалтууд, "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.2.2. дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-эрдэнэ) нь ажлаас чөлөөлөгдөж байгаатай холбогдуулан эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж явуулсугай.

2.Тооллого зохион байгуулж явуулах эрх бүхий тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга: Б.Долгорнямаа	ЖДҮХХ-мэргэжилтэн
Нарийн бичиг: Ө.Өнөрөө	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Гишүүдэд: Ш.Баасандорж	Байгаль орчны хяналтын Улсын байцаагч
Д.Золзаяа	Чандган багийн засаг дарга
Б.Бямбадорж	Байгаль хамгаалагч

3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

4.Тооллогын комисс нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дүгээр зүйлд заасан "Эд хөрөнгийн тооллого явуулах журам"-ыг баримтлан явуулахыг комиссын дарга (Б.Долгорнямаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

  
Н.НАМЖИЛНОРОВ